



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 14 өдөр

Дугаар А/310

Мөрөн сум

Гэрийн тэжээвэр амьтан нохой,
муурыг бүртгэлжүүлж туулгалтад
хамруулах ажил зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4, Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2, 10 дугаар зүйлийн 10.1, 10.2, 33 дугаар зүйлийн 33.1 дэх заалт, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/126 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд гэрийн тэжээвэр амьтан нохой, муурыг бүртгэлжүүлэх, туулгалтад хамруулах арга хэмжээг 06 дугаар сарын 17-ний өдрөөс эхлэн зохион байгуулсугай.

2.Гэрийн тэжээвэр амьтан нохой, муурыг бүртгэлжүүлэх, туулгалтад хамруулах арга хэмжээг суурь судалгаа, тандалтыг үндэслэн графикт хугацаанд мэргэжлийн байгууллагаас гаргасан заавар зөвлөмжийн дагуу зохион байгуулж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Гэрийн тэжээвэр нохой, муур бүртгэлжүүлэх, туулгалтад хамруулах арга хэмжээг зохион байгуулахад нэгдсэн удирдлага, мэргэжил арга зүйгээр ханган, ажлын явцад технологийн хяналт тавьж ажиллахыг аймгийн Мал эмнэлгийн газрын дарга (Л.Ариунаа)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамжийн хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ